

## Интернэт ба Өнөөдрийн хүүхэд, залуус

Бидний үед хүүхэд залуусын хүмүүжилд ном голлох үүрэг гүйцэтгэдэг, түүнээс өөр сайн найзгүй байлаа. Өнөөдөр тэр үе хурдан өөрчлөгдөж байна. 70,80-аад оны хүүхэд залууст телевиз нэмэгдэж оюуны хэрэгцээгээ хангахад тодорхой хэмжээгээр нөлөөлж байсан. Харин 90-ээд онд төрсөн хүүхдүүдэд Интернэт ердийн зүйл болоод байгааг бид анзаарахгүй байхын аргагүй. Тэд шинэ зууны залуус болж өсөн торних бөгөөд тэднийг шинэ үе, технологийн, мэдээллийн эрин зуун хүлээж байна.

Компьютерийн технологийн ертөнцийн эзнээр тодроод байгаа, тэрбумтан Билл Гейтес нэгэн уулзалтан дээр хэлэхдээ: “Тухайн үедээ хэвлэмэл ном бий болсноор хүмүүсийн боловсрол, оюун санааны хэрэгцээ хэрхэн өөрчлөгдсөн шиг Интернэт боловсролыг, боловсролын системийг сууриар нь өөрчлөх болно... Иймд бидний, томчуулын өмнөө тавих нэг гол зорилт бол багш, сурган хүмүүжүүлэгч бүр интернэтийг ашиглаж чаддаг болох, шинэ үеийг сургах чадвартай болоход нь бүх талаар туслах явдал...” гэжээ. Тиймээ би яг энэ санааг дэмжигчдийн нэг. Энэ бол зөвхөн өндөр хөгжилтэй орнуудын зорилт биш, үүнийг монголчууд бид ч санаж явах ёстой, хэрэгжүүлэх бүхий л бололцоог эрэлхийлэхэд хамтран ажиллах хэрэгтэй гэж боддог юм.

Интернэт боловсролын салшгүй хэсэг болон хөгжиж байна. Интернэт гэж юу вэ гэвэл, Интернэт бол дэлхий даяар тарсан, дэлхийг бүрхэн хэрсэн мэдээлэл, техник, программ болон хүмүүсийн нийлмэл цогц юм. Интернэтийг 1969 онд АНУ-ын АРПА гэдэг эрдэм шинжилгээний байгууллага санаачлан засгийн газрын болон их сургуулийн компьютерүүдийг хооронд нь холбосон сүлжээ байгуулснаар үүссэн гэж үздэг. Тэгвэл одоо Интернэт нь урд өмнө дэлхий дээр хаа ч байгаагүй мэдээллийн дардан зам буюу холбоо харилцааны, эрдэм мэдлэгийн, судалгаа шинжилгээний, мэдээллийн агуу орчин болон өргөжиж байна. Интернэт хэрэглэгчийн тоо 100 саяд хүрч, өсөлт нь сард дунджаар 15 хувьд хүрсэн нь түүний хэр хурдацтай, далайцтай хөгжиж байгаагийн илрэл юм. Зөвхөн АНУ-д л гэхэд улсын сургуулийн 90 хувь нь Интернэтэд ямар нэг хэлбэрээр холбогдсон, багш нарын 54 хувь нь сургалтандаа интернэтийг ашигладаг, 16 сая гаруй хүүхэд онлайнаар холбогддог бөгөөд 2002 оны эх гэхэд 7-12 настай хүүхдүүдийн 40 хувь нь гэртээ юмуу сургуульдаа интернэтэд ямар нэг хэлбэрээр ханддаг болно гэсэн судалгааны баримт бий. Үүний хажуугаар америкийн багш нарын 20 хувь нь л өөрийгөө орчин үеийн технологийн орчинд, шинэ маягийн “анги танхим”-д сургалт явуулахад бэлэн байгаа гэж дүгнэсэн байна. Энэ тоо баримтууд далайн чанадад байгаа бодит зүйл.

Тэгвэл манайд ямар байгаа вэ гэдгийг судалгааны баримтад түшиглэн хэлье. Манай улс ерөнхий боловсролын 668 сургууль, 100 гаруй их дээд сургууль, коллежтой. Боловсролын салбарт нийтдээ 6000 гаруй компьютер ашиглагдаж байгаагийн 1200 нь дунд сургуульд байдаг байна. Энэ нь нэг сургуульд дунджаар ердөө л 3-4 компьютер оногдож байгаа гэсэн үг бөгөөд тэдгээрийн тал нь сургалтанд ашиглагдаж байгаа гэж тооцвол үнэхээр чамлалттай үзүүлэлт. Их дээд болон мэргэжлийн сургуулийн хувьд байдал арай дээр, нийтдээ 3000 гаруй компьютер байгаа, тэдгээрийн 75 хувь нь сургалтанд ашиглагддаг гэсэн бүрэн бус мэдээ бий. Интернэтэд холбогдсон байдлыг нь авч үзвэл ерөнхий боловсролын 44 сургууль, 30-аад их дээд, мэргэжлийн сургууль ямар нэг хэлбэрээр Интернэтэд холбогджээ. Интернэтийг сургалтандаа ашиглах явдал дөнгөж эхлэлийн төдий л байна. Үүнийг саяхан УБ хотноо болсон “Интернэт ба сургууль-2000” олон улсын хурлын үеэр болсон хэлэцүүлгийн үеэр илүү тод мэдэрсэн. Энэ хуралд багш сурагчид голлон оролцож, бодлого боловсруулагчид, гадаад дотоодын эксперт, мэргэжилтнүүдийн хамтаар монголын боловсролын салбар дахь интернэтийн хэрэглээ, ялангуяа дунд сургуулийн түвшин ямар байгаа талаар саналаа солилцож, сургалтандаа интернэтийн технологийг тодорхой түвшинд хэрэглэж байгаа сургууль, багш нарынхаа хүрсэн амжилтыг сонсож, цаашид юу хийх вэ, яах вэ гэдэг дээр харилцан зөвшилцсөн нь маш чухал алхам болсон.

Интернэтийг хүүхэд залуус хэрхэн хэрэглэж байна вэ гэдгийг тодорхойлох нь бас нэг сонирхолтой зүйл. Интернэтэд холбогдсоноор өнөөдөр имэйл буюу электрон шуудан /e-mail/, файл дамжуулах үйлчилгээ /FTP/, мэдээллийн үйлчилгээ /ж: UseNet News/, теле холбоо /Telnet/, интернэт ярилцлага /chat, IRC/, вэб /WWW/, аудио видео хурал-ярилцлага

/Audio Video Conferencing/, тоглоом /Game/ зэрэг олон үйлчилгээг ашиглаж болно. Үүнээс хүүхэд, залуусын хэрэглэх дуртай нь имэйл, интернэт ярилцлага, тоглоом, вэб гэж судалгаагаар тодорхойлогдсон байна. Интернэтийг ашиглах нь хүүхэд залууст өөрсдийгөө цоо шинээр нээх, өөрийгөө бүрэн дайчилж сурах, олон үндэстний зан заншил, соёлтой танилцах, сэтгэн бодох, бичих ур чадвараа дээшлүүлэх, өөрийн орчин нийгэмд илүү гүн гүнзгий татагдан орох, сайн дурын төсөлд оролцох, бусдад туслах, дугуйлан секцэнд хамрагдах, найз нөхөдтэй болох зэргээр эерэг нөлөө үзүүлж байна гэсэн судалгааны дүнг би интернэтээс уншиж байсан юм. Эцэг эхчүүд гэрээсээ хол сурч байгаа хүүхдүүдээсээ имэйл авах нь олширч байгаад гайхан баярлаж, хүүхдүүд нь гэрийнхэнтэйгээ утсаар ярьж, биеэр уулзсанаас илүү нээлттэй харьцаж байна гэж бичсэн байсныг санаж байна. Америкт 2-17 настай хүүхэдтэй 1700 гаруй гэр бүл, тэдний 9-17 насны хүүхдүүдийн дунд хийсэн судалгаагаар эцэг эхчүүд хүүхдүүдээ интернэттэй нөхөрлөхийг дэмжиж байгаагаа илэрхийлжээ. Гэхдээ сайны хажуугаар саар гэгчээр интернэт хүүхэд залууст муу нөлөө үзүүлж байгаа ч баримт бий. Томчуулд зориулсан материал үзэх, бусдад уруу татагдах, гаж хэлээр ярьж бичих зэрэг үзэгдэл ч гарч байна. Австралид хүүхдүүдийг уруу татдаг 5000 гаруй тохиолдлыг илрүүлж, үйл ажиллагааг нь зогсоосон жишээ бий. Мөн Англид 60 хүүхдийн дунд явуулсан судалгаагаар 45 хувь нь хүсээгүй үедээ хориотой материал олж үзсэн гэсэн дүн гарчээ.

Эдгээр нь интернэтийн хэрэглээг дэмжих, ялангуяа хүүхэд залуусдаа ийм нөхцөлийг бүрдүүлж өгөх нь тэдний боловсрол, хүмүүжилд тусалж, мэдлэгийн хүрээгээ тэлэх асар өргөн боломж олгоно гэдгийг харуулахын зэрэгцээ анхнаас нь зүй зохистой хэрэглээг бий болгоход анхаарах хэрэгтэйг бидэнд сануулж байгаа юм.

Интернэт нь хүүхэд залуусыг өөртөө итгэлтэй болгох, арьс өнгө, нас хүйс, нүүр царай, биеийн галбираас үл хамааран эрх тэгш бусадтай харьцах, харилцан суралцах, өөрийгөө илэрхийлэх, өөрийн шинэ чадвараа нээхэд сайнаар нөлөөлнө.

Гэвч нэг зүйлийг бид ойлгох ёстой. Интернэт алга болохгүй, улам л өргөжин тэлнэ. Интернэт шинэ зууны харилцааны гол хэрэглүүр, орчин болно. Тэгэхлээр хүүхэд залуусыг Интернэтээр зөвхөн хэрэн зугаалахад ашиглаж сургах төдийгүй хэрхэн ухаалгаар хэрэглэж сурах вэ гэдэгт зөвлөж туслах нь маш чухал.

Монголчууд бид хоцрогдлоороо гайхуулах дуртай, түүгээрээ далимдуулж зээл тусламж олж авах бүр ч дуртай улс. Тэгвэл түүнийхээ тодорхой хэсгийг шинэ зуунд амьдрах хүүхэд залуустаа оюуны хэрэгцээгээ хангахад нь, бусад орны үе тэнгийн залуусаасаа хоцрохгүй байхад нь туслах зорилгоор зарцуулахад анхаарлаа хандуулмаар байна. Интернэтийг сургууль бүрт, анги бүрт, хүүхэд залуус бүрт хүргэхийн төлөө хамтран ажиллацгаая. Ирээдүйгээ авч явах иргэддээ боловсролын хөрөнгө оруулалт хийцгээе!

Б.Наранцэцэг  
ИнфоКон ХХК  
2000/09/05